



БОЛОВСРОЛЫН  
ЯАМ

**№ 03/6.1-3. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН  
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХ  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

**I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалтын удирдамжийн дугаар:

Хяналт шалгалт эхэлсэн огноо:...../...../.....

Хяналт шалгалт дууссан огноо:...../...../.....

Шаардлага хангасан  
асуултын тоо:

Хууль сахин  
мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй  
нийт оноо:

Эрсдэл үүсэх  
магадлалын хувь:

Эрсдэл үүсэх  
магадлал

**II. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Шалгуур	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
	1	2	3	4	5	6
<b>I. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>			<b>0</b>	<b>120</b>		
1	Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 2.2.4 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 8.1.7.4, 8.1.7.10, 8.1.7.11, 8.1.7.12; 8.2 дугаар зүйлийн 8.2.6.14; Боловсролын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.11	Боловсролын сургалтын байгууллага нь тусгай зөвшөөрөлтэй, улсын бүртгэлд Боловсролын сургалтын байгууллагаар бүртгүүлсэн. Үүсгэн байгуулах гэрээ, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, оршин байгаа хаягийн өөрчлөлтийг бүртгүүлсэн.	0	10		
2	Боловсролын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.4	Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад бичигдсэн сургалтад баримтлах шаардлагын үзүүлэлтүүдийг мөрддөг	0	10		
3	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь магадлан итгэмжлэгдсэн.	0	10		
4	Боловсролын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.3, 34.6; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.3, 26.4, 26.6 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/584 дүгээр тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургал-тын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм"	Боловсролын сургалтын байгууллага нь хуульд заасан удирдах /захиргааны/ зөвлөлтэй. Удирдах зөвлөл нь сургалтын байгууллагыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэлэлцэн баталж, үйл ажиллагааны тайлан, сургалтын үр дүн, чанар, гүйцэтгэлийг хэлэлцэж дүгнэдэг.	0	10		

5	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.1; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3, 27.4; 2	Захирал нь хуульд заасан тавигдах шаардлагыг хангасан.	0	10		
6	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5; "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай"-ын Зорилт 2.1, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/-ын 1.3.1, 2.1.1, 2.1.7, 3.6; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм"	Захирал нь байгууллагыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол олгох ажлыг удирдан зохион байгуулдаг.	0	10		
7	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 209 дүгээр тогтоол "Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр"	Эко орчныг бүрдүүлэх, ногоон хөгжлийн талаарх мэдлэг чадвар түгээх, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл аюулгүй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилтуудыг хөгжлийн хөтөлбөртөө тусгаж хэрэгжүүлсэн.	0	10		
8	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2; 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3; 13 дугаар зүйл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 12 дугаар тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлт, төгсөлтийн журам", "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал"	Суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоог баримтлан элсэлтийн үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулдаг.	0	10		
9	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/13 дугаар тушаал "Журам, загвар батлах тухай" Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчид олгох боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журам"	Төгсөгчдөд батлагдсан журмын дагуу боловсролын бичиг баримт олгогдсон.	0	10		
10	Боловсролын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.3; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 20 дугаар зүйл, 27 дугаар зүйлийн 27.5.6; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/313 дугаар тушаал "Маягт, түүнийг нөхөх заавар"	Суралцагчийн болон статистикийн бусад шаардлагатай тоо, мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн, зөв гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулдаг.	0	10		

11	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйл,	Багш, ажилтан хууль тогтоомж, дүрэм журамд заасан нийгмийн баталгаагаар хангагдаж, тэтгэмж урамшуулалд хамрагддаг.	0	5		
12	Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3; 38 дугаар зүйлийн 38.1.5; Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.4.3.	Удирдлагын зүгээс багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, багшийг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулдаг.	0	5		
13	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.1, 23.2, 23.3, 23.4, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.4.8.	Хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж баталсан. Сургуулийн орчинд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.	0	10		
<b>II. СУРГАЛТЫН ОРЧИН</b>			<b>0</b>	<b>115</b>		
<b>A. ХИЧЭЭЛИЙН БАЙР</b>			<b>0</b>	<b>30</b>		
14	Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 39.4, 39.8, 39.9; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9; 27 дугаар зүйлийн 27.5.9; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2; "Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага MNS6541:2015" стандартын 10.1.	Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй сургалтын орчныг бүрдүүлсэн.	0	10		
15	Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5.	Сургалтад зориулсан эзэмшил газартай.	0	10		
16	Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.4.7.	Барилга байгууламж, эзэмшил газрыг зориулалтын дагуу ашигладаг.	0	10		
<b>Б. ДАДЛАГЫН ГАЗАР, ЛАБОРАТОРИ</b>			<b>0</b>	<b>70</b>		
17	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 7 дугаар зүйл, "Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага MNS6541:2015" стандартын 10, 11 дэх хэсэг.	Сургалт явуулж буй мэргэжил тус бүрээр өөрийн дадлагын газартай.	0	10		
18		Тухайн мэргэжлийг эзэмшүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, тоног төхөөрөмжийн жагсаалтыг тодорхойлсон.	0	10		
19		Дадлагын газарт багшийн өрөө, багаж хэрэгсэл хадгалах, суралцагчдын ажлын хувцас солих орчинг бүрдүүлсэн.	0	10		

20		Дадлагын газар, лаборатори хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан, тоног төхөөрөмж хоорондын зай, талбайн хэмжээ стандартад нийцүүлэн суурилуулсан.	0	10		
21		Дадлагын газар, лаборатори, сургалтын талбай, туршилт үйлдвэрлэлийн цехэд ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмжид баталгаажуулалт хийлгэж, дүгнэлт гаргуулан гэрчилгээ авсан.	0	10		
22		Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь нэг бүлэгт 15 сурагч ашиглах боломжтой.	0	10		
23	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм"-ийн 3.4.10.	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохирох тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй.	0	10		
<b>В. НОМЫН САН</b>			<b>0</b>	<b>15</b>		
24	Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3; "Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага" MNS5742:2019 стандарт, "Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага MNS6541:2015" стандартын 12 дахь хэсэг	Нийт суралцагч, багшийн 15-аас доошгүй хувьд хүрэлцэхүйц суудал бүхий уншлагын танхимтай.	0	5		
25		Заавал ашиглах шаардлагатай мэргэжлийн болон техникийн боловсролын сурах бичиг, цахим ном нийт номын 60-аас дээш хувийг эзэлдэг.	0	5		
26		Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сурах бичиг 3 суралцагч тутамд 2-оос доошгүй ногддог.	0	5		
<b>III. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>			<b>0</b>	<b>80</b>		
27	Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.4; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.7, 6.8, 6.9, 6.10; 27 дугаар зүйлийн 27.5.2, 27.5.7 дахь заалт, "Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага MNS6541:2015" стандартын 5.1 дэх хэсэг, Боловсролын сайдын 2025 оны А/563 дугаар тушаал "Сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загвар", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/269 дугаар тушаал "Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журам"	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт тавих шаардлагын дагуу боловсруулж батлуулсан	0	10		

28	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалт	Эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжлүүлсэн	0	10		
29	Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6;	Бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх хичээлүүд нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн хуваарьт тусгагдсан, ерөнхий эрдмийн хичээлүүд бүрэн ордог. Заавал тусгах агуулгыг тусгасан.	0	10		
30	Боловсролын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.3; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг явуулдаг, хөтөлбөрт тохируулга хийсэн.	0	5		
31	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7; 10 дугаар зүйлийн 10.1.1; 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4; “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага MNS6541:2015” стандартын 5.2; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 5.1, 5.2.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хуваарийн дагуу онол, дадлагын хичээл, сургалтыг зохион байгуулдаг.	0	10		
32	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5; 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3;	Дадлагын ажил хийхэд шаардагдах хүрэлцэхүйц материал, хамгаалах хувцас хэрэгслээр хангагдсан.	0	10		
33	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.5; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 5.5.	Үйлдвэрлэлийн дадлагын ажил хийх гурван талт гэрээ байгуулсан.	0	5		
34	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 5.4.	Үйлдвэрлэлийн дадлагыг сургалтын төлөвлөгөө, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, удирдамжийн дагуу зохион байгуулдаг.	0	10		
35	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 3 дүгээр зүйлийн 3.1.10; 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Боловсролын сайдын 2025 оны А/544 дүгээр тушаал “Хосмог сургалт зохион байгуулах журам”	Хосмог сургалтыг холбогдох хууль, журамд заасны дагуу үйлдвэрлэлийн дадлагажуулагч, аж ахуйн нэгжтэй хамтран хэрэгжүүлдэг. Сургалтын хөтөлбөрийг журмын дагуу боловсруулсан.	0	10		

IV. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН		0	60			
36	Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, 12.9; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3; “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага MNS6541:2015” стандартын 9.1, 9.2; Боловсролын сайдын 2025 оны А/405 дугаар тушаал.	Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш нь тухайн мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 3-аас доошгүй жил ажилласан, мэргэшлийн өндөр ур чадвартай, багшлах эрхтэй.	0	10		
37		Техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь тухайн мэргэжлийн чиглэлээр магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 5-аас доошгүй ажилласан туршлагатай, мэргэшлийн өндөр ур чадвартай, багшлах эрхтэй.	0	10		
38		Сургалтын заах арга зүй эзэмшсэн, үйлдвэрлэл, технологийн дадлага удирдах эрх бүхий үндсэн багшаар хангагдсан.	0	10		
39		Ерөнхий эрдмийн хичээл, сургалтыг зохион байгуулах мэргэжлийн багшаар хангагдсан. /насанд хүрэгчдийн мэргэжил олгох 1 жилийн сургалтын байгууллагад хамаарахгүй байж болно/	0	10		
40	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4; 15 дугаар зүйлийн 15.2.1, 15.2.2, 15.2.3;	Багшийн үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилласан, багшийн мэдлэг, ур чадварын үнэлгээнд хамрагдсан.	0	10		
41	Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5, 13.2.6, 13.2.7, 13.2.10, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 4.3.	Багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдүүлдэг, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн зохион байгуулдаг.	0	10		
<b>V. СУРАЛЦАГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ</b>		<b>0</b>	<b>35</b>			
42	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/128 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам”	Төгсөгчид ажил олгогчоос тавьж буй шаардлагыг хангаж буй эсэхэд чанарын судалгаа хийдэг.	0	5		
43		Сүүлийн 2 жил төгсөгчдийн 60-аас доошгүй хувь нь мэргэжлээрээ ажлын байртай болсон.	0	5		
44	Боловсролын ерөнхий хуулийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17 дугаар зүйл	Суралцагч эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн	0	10		
45		Сургалтын байгууллагын үйл ажиллагааны талаар багш, суралцагчаас санал асуулга авч, дүн шинжилгээ хийдэг, гаргасан санал, шүүмжлэлийг хүлээн авч, хэрэгжүүлдэг.	0	10		

46	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 19 дүгээр зүйлийн 19.3.13 дахь заалт	Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад үйлдвэрлэлийн дадлага хийхэд Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу цалин хөлсөөр хангагддаг.	0	5		
<b>VI. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ</b>			<b>0</b>	<b>30</b>		
47	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалт	Сургалтын байгууллагын нийгмийн түншлэл нь аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, суралцагчийн төлөөллөөс бүрдсэн.	0	5		
48	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.7, 10.1.10 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.4.11.	Түншлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг.	0	10		
49	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.4.2.	Төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулсан.	0	10		
50	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, 15.1.8 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг ажил олгогчдод танилцуулах, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулдаг.	0	5		
<b>VII. ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ, ДОТООД ХЯНАЛТ</b>			<b>0</b>	<b>25</b>		
51	Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.7, 35.8; Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7; Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/585 дугаар тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 3.4.6.	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлдэг. Чанарын баталгаажуулалтын үр дүнд үндэслэж, чанарын сайжруулалтын төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн.	0	10		
52	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Засгийн газрын 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам баталсан, ажилтныг томилон ажиллуулсан.	0	5		
53		Дотоод хяналт шалгалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийдэг, илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.	0	10		
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>465</b>		

## II. ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

<b>ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:</b> ..... ..... .....
<b>БИЕЛЭЛТ:</b> ..... ..... .....

<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
<i>/овог, нэр/</i>	<i>овог, нэр/</i>	<i>/овог, нэр/</i>
<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: .....

.....

## IV. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

<b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:</b> ..... ..... .....
<b>БИЕЛЭЛТ:</b> ..... ..... .....

### ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Хяналт шалгалт хийсэн огноо: 20__ он __ сар __ өдөр		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
<i>/овог, нэр/</i>	<i>/овог, нэр/</i>	<i>/овог, нэр/</i>
<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: .....

.....

.....

- Их эрсдэлтэй                    >=50%
- Дунд эрсдэлтэй                [30%-49%]
- Бага эрсдэлтэй                <=29%